

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 06 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж 2 асуудал хэлэлцэж, 2 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 33 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 29, биечлэн 4 иргэн санал, гомдол ирүүлснээс гомдол 24, санал хүсэлт 7, шүүмжлэл 2 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 30 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэж шийдвэрлэлт 90.9 хувьтай байна. Орчны эрүүл ахуйн чиглэлээр 13, хууль эрх зүй 3, эрүүл мэнд 3, боловсрол 1, бусад 13 санал хүсэлт хүлээн авсан байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцагаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу энэ сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 14 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж 13 санал хүсэлтийн хариуг илгээж, 1 санал хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 6 дугаар сарын санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг санхүүжүүллээ.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг сар бүр олгож байна.

Өнгөрсөн 2016 онд малын гоц халдварт мялзан өвчний үеэр гарсан 118,5 сая төгрөгийн зардлыг сум, байгууллагад шилжүүлж өр барагдууллаа.

Орон нутгийн 2017 оны тодотгосон төсвийн төслийг боловсруулан аймгийн ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаар 6 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцүүлэн батлууллаа. ИТХ-аар батлагдсан төсвийн тодотголыг сум, байгууллагуудад аймгийн Засаг даргын 1/1432 дугаар албан бичгээр хүргүүлэн сумдыг төсвийн тодотголоо батлуулан ирүүлэх талаар чиглэл өгөв.

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын зөвлөмж, төлөвлөгөөний дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС, Засаг дарга дансны авлагын жагсаалтыг гарган ХОХБТХ, Хууль эрх зүйн хэлтэст албан бичгээр хүргүүлж, авлага барагдуулах талаар хамтран ажиллаж байна.

Мөн төрийн Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр Орон нутгийн өмчийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар зэрэг байгууллагуудад албан бичиг хүргүүлэн зөвлөмж, албан шаардлага хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт тавин ажиллаж байна.

“Төсвийн талаар авах арга хэмжээ”-ний талаар хэлтсийн даргын албан бичиг гарган сум, байгууллагуудад хүргүүлж, төсвийн орлого биелүүлэх, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх, өр, авлага бууруулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахаар үүрэг чиглэл өгөв. Тус ажлын хүрээнд сум, байгууллагуудын өр, авлагын судалгаа гаргаж, төсвийн байгууллагуудын хэмнэгдсэн зардлыг хүрэлцэхгүй өр үүсч байгаа зардлын бүлэг хооронд зохицуулалт хийж, өглөг, авлагыг бууруулан ажиллалаа.

Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох

заалтуудын биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж хугацаанд нь Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлээ.

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас тайлант сард Төсвийн ерөнхийлэн захирагчийн төлөвлөгөөнд тусгагдсан Ховд АЗЗА ТӨХК, Биеийн тамир спортын газар, 12 жилийн 1 дүгээр сургууль, Политехник коллеж, Сангийн сайдын удирдамжийн дагуу Ховд Авто тээврийн төв зэрэг 5 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийв. Уг шалгалтаар үндсэн баримтгүй зарцуулсан болон бүртгэлд тусгаагүй, сэлбэг хэрэгслийн норм тооцдоггүй, ур чадвар, үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгодог, жолоочийн тооцоо боддоггүй, замын хуудас хөтлөөгүй, төсвийн хөрөнгөөр цайллага зохион байгуулж үрэлгэн зардал гаргаж байгаа зөрчлүүд нийтлэг илэрч байгааг тогтоон 56,3 сая төгрөгийн төлбөр төлүүлэхээр акт тогтоосон болно.

Улс, аймаг, сум орон нутгийн төсөвт нийт 5348.4 сая төгрөг оруулахаас 4723.4 сая төгрөг орж, төлөвлөгөө 88.3 хувиар, үүнээс улсын төсөвт 694.1 сая төгрөг орж, төлөвлөгөө 69.7 хувиар, аймгийн төсөвт 3390.9 сая төгрөг орж төлөвлөгөө 86.7 хувиар, сумын төсөвт 638.7 сая төгрөг орж төлөвлөгөө 145.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант сард 8 аж ахуйн нэгж, 2 иргэнийг хамруулан хяналт шалгалтыг хийж, шалгасан татвар төлөгч бүрт гаалийн мэдээлэл, хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр 133.3 сая төгрөгийн зөрчилд 13.5 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 4.5 сая төгрөгийн торгууль, 3.3 сая төгрөгийн алданги, нийт 21.3 сая төгрөгийн нөхөн татвар хүү, торгууль, алданги ногдуулж ажиллалаа.

Статистикийн хэлтсээс ажиллах хүчний судалгааг Жаргалант сумын Жаргалан, Булган сумын Бүрэнхайрхан, Үенч сумын Нарийн гол багуудад, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Наран, Буянт сумын Норжинхайрхан, Эрдэнэбүрэн сумын Шураг багуудад нийт 62 өрхөд тус тус хийж, судалгааны материалаа хянан баталгаажуулж байна.

Хагас жилийн мал тооллогыг аймгийн Засаг даргын 235 дугаар захирамж, 1/1388 дугаар албан бичиг гаргуулан, сумдын Засаг дарга нарт хүргүүлж 6 дугаар сарын 1-15-ны өдрүүдэд хийж дуусгав.

“Бичил уурхай” эрхлэгчдийн тооллогын ажлыг хэлтсийн даргын тушаалаар Булган, Цэцэг, Үенч, Алтай, Дөргөн сумдад дахин хийж, тооллогын хугацаанд 14 хоног тутамд бичил уурхай эрхлэгчдийн ирцийн мэдээг Үндэсний статистикийн хорооны цахим шууданд хугацаанд нь дамжуулж ажиллав.

Статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, түгээлт, хуваарилалт, алдагдлыг салбаруудаар тодорхойлох, эрчим хүчний статистикийн мэдээллийг бүрдүүлэх зорилгоор хийгдсэн “Эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэл” судалгааг 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 18-ны хооронд зохион байгуулж түүвэрлэгдсэн 19 аж ахуйн нэгжээс мэдээллийг авч судалгааны материалаа ҮСХ-д хүргүүлээ.

ҮСХ-ноос хийгдсэн “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд амьдралын судалгаа”-нд аймгийн 17 багийн 255 өрх хамрагдсан бөгөөд хэлтсийн ажилтнууд багуудын өрхийн жагсаалтыг бэлтгэж, судалгааны баг, багийн дарга нартай хамтран ажиллав.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран 200 албан тушаалтныг хамруулан 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхлэх Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Прокурорын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудаар 5 өдрийн сургалт зохион байгуулав.

Хэлтсийн хурлыг 4 удаа хийж, 9 иргэнд хууль зүйн зөвлөгөө өглөө.

Засгийн газрын 2 тогтоолд өөрчлөлт хөдөлгөөн оруулав. Сумаас ирүүлсэн 2 зөрчлийн мэдэгдэл тайлбарыг аймгийн Засаг даргаар хянуулан батлуулж хүргүүлэв.

Архивын тасгаас 40 хүнд захирамж, тушаалын лавлагааг олгосон бөгөөд 1991-1995, 1970-2006 оны 2 хөмрөгийн 2 дансны 42 ширхэг хадгаламжийн нэгжийн 4716 хуудас материалыг цахим системд шивж оруулав. Сан хөмрөгийн өрөөнд засвар хийж Архивын Ерөнхий газраас 20 ширхэг тавиур авч баримтыг байрлуулсанаар архивын баримт бичгийн хадгалт, хамгаалалт сайжирлаа.

Цагдаагийн газар: Иргэд олон нийтэд хууль эрх зүйг сурталчлан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2017 оны 06 дугаар сард дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд: Аймгийн хэмжээнд зохион явагдаж буй “Хууль журам-миний амьдралд” аяны хүрээнд “Мянган Угалзат” ОНӨААТҮГ-ын 28, Гадаадын иргэн, харьяатын Баруун бүсийн газрын 12, Ус цаг уур орчны шинжилгээний 18 ажилтанд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо” сэдэвт сургалт хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Булган, Алтай, Үенч сумдын 60 иргэнийг хамруулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо”, “Хууль дүрэм-бидний амьдралд” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Сургалтын агуулгыг оролцогчдод илүү ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхийн тулд багаар ажиллуулж, асуулт хариултын тэмцээн зохион явуулж, тэргүүлсэн иргэдийг шагнаж урамшуулав.

Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Прокурорын газартай хамтран зүүн бүсийн 6 сумдын 200 иргэнд “Хууль сурталчлах өдөрлөг”, хууль сурталчилах дэвжээ тэмцээн зохион байгуулж, тэргүүлсэн баг, хамт олныг урамшуулсан. Дэлхий нийтээрээ “Тамхи хэрэглэдэггүй, татдаггүй өдөр”-тэй холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын байцаагчидтай хамтран “Тамхины хэрэглээ ба хор хөнөөл”, “Дам тамхидалт надад хортой”, “Хүүхдийнхээ дэргэд тамхи бүү татаарай” зурагт мэдээллийг баар, дэлгүүр, зоогийн газар болон үйлчилгээний төвүүдийн мэдээллийн самбарт байршуулав. Улсын хэмжээнд насанд хүрээгүй хүмүүс ахуйн хэрэглээний газ үнэрлэж мансуурсан асуудалтай холбогдуулан энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим сайтуудад сэрэмжлүүлэг мэдээллийг нийтлүүлэн, 18 насанд хүрээгүй хүнд ахуйн хэрэглээний газ худалдаалахыг хориглох талаар аймгийн Засаг даргын захирамжийн төсөл, Жаргалант сумын хэмжээнд ажиллах “Урамшилт эргүүл”-ийн журмын төслийг аймгийн ГХУСАЗСЗ-д тус тус хүргүүлсэн боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

Сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, мансууруулах төрлийн бодис, үр хөндөлтийн эсрэг эмийг 18 насанд хүрээгүй хүнд худалдаалахгүй байх талаар 20 эмийн санд Цагдаагийн газрын албан мэдэгдэл хүргүүлэн, яриа таниулга хийж, хяналт тавьлаа.

Сонгуулийн сурталчилгааны үед бусдын хуулиар хамгаалагдсан эрхэнд халдаж гүтгэн доромжлох, Сонгуулийн тухай хууль зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 төрлийн сэрэмжлүүлэг, зөвлөмжийг орон нутгийн 2 телевизээр 3 өдөр, өдөрт 3 удаагийн давтамжтайгаар, нийт 18 удаа нэвтрүүлж цахим сайтуудад уг сэрэмжлүүлэг мэдээллийг видео хэлбэрээр болон бичгээр нийтлүүлж олон нийтэд хүргэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураах өдөр нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гарч болзошгүй тул энэ өдөр архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулахгүй байх талаар аймгийн Засаг даргын 2017 оны А/254 дүгээр захирамж гаргуулан, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг 182 аж ахуйн нэгжид захирамжийг хэрэгжүүлэх талаар Цагдаагийн газрын мэдэгдлийн хамт хүргүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл өгч, цахим сайтуудад нийтлүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2017 оны 06 дугаар сарын 26-ны байдлаар 39 гэмт хэрэг бүртгэгдсэн. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: бусдын бие махбодид гэмтэл учруулах 14, хулгайлах 10, үүнээс иргэдийн өмчийн хулгай 9, малын хулгай 1,

тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмыг эсрэг гэмт хэрэг 8, хүнийг санаатай алах гэмт хэрэг 1, бусдыг амиа хорлоход хүргэх 1, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг 1, байгаль хамгаалах журмын эсрэг 1, бусдын эд хөрөнгө завших 1, бусдын эд хөрөнгө санаатай устгах 1, бусдын эд хөрөнгө залилан мэхлэх гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдлээ.

Тус Цагдаагийн газраас 06 дугаар сарын 26-ны байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 353 гомдол мэдээлэл хүлээн авсаны гэмт хэрэг 70 буюу 19.8 хувийг гэмт хэргийн талаарх, 277 буюу 78.4 хувийг захиргааны зөрчлийн талаарх, 6 буюу 1.7 хувийг бусад гомдол мэдээлэл эзэлж байна.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 14 гомдол мэдээлэл тус тус бүртгэгдэв.

2017 оны 06 дугаар сарын 26-ны байдлаар зөрчил гаргасан 83 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 24 хүнийг 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлуулж, 65 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 938 хүнийг 54.474.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч ажиллалаа.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны 2016-2017 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр батлагдсан журмуудаар сэдэвчилсэн сургалт зохион байгуулав.

Шүүхийн шинжилгээний албанд хандаж 18 албан бичиг, 71 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 15 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Эрдэнэбүрэн суманд Хууль сахиулах байгууллагуудтай хамтран хууль сурталчилах, олон нийтэд хүргэх “Нээлттэй хаалганы өдөр”-ийг удирдамжийн дагуу зохион байгуулж, хүрэлцэн ирсэн иргэд, үйлчлүүлэгч нарт гарын авлага тарааж шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааг сурталчилав. Өдөрлөгийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2017 оны 06 дугаар сарын 21-22 ны өдрүүдэд Увс аймагт зохион байгуулсан адистатчилалын шалгалтанд алба хаагчдыг 100 хувь хамруулав.

“Дугуйтай өдөрлөг”-ийн арга хэмжээг аймаг орон нутгийн хэмжээнд санаачилан зохион байгуулж, үйл явцыг орон нутгийн телевиз болон цахим сүлжээгээр олон нийтэд мэдээлэв.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 6 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 41 хүнд, химийн шинжилгээ 24, биологийн шинжилгээ 16, криминалистикийн шинжилгээ 13 тус тус хийж, нийт 100 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд 6 удаа явж үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлэв.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 44 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 26 ширхэг мөр, гутлын мөр 16, тээврийн хэрэгслийн мөр 26, бусад ул мөр, эд мөрийн баримт 43 илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 63, гарын мөр 16 тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн шинжилгээ, химийн шинжилгээ, биологийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүрт нь цахимжуулав.

2017 онд улсын төсвөөс нийт 187,519,000 төгрөгийн төсөв батлагдсанаас 2017 оны эхний 6 сарын байдлаар цалин хөлс нэмэгдэл урамшилд, Нийгмийн даатгал, хангамж бараа материал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 69.845.314 төгрөгийг зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулав.

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллийг боловсруулж Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлэв.

Сар бүрийн мэдээг дараа сарын 2-ны дотор Төрийн сангаар баталгаажуулан Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

Төлбөрт үйлчилгээний орлогод 1,440,500 төгрөг төвлөрүүлээд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба-Хорих 457 дугаар анги: Тус алба нь нийт 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар шийдвэр гүйцэтгэгч 2, дэд бөгөөд гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт хариуцсан дарга 1, нярав 1 нийт 4 албан хаагч томилогдоогүй 60 алба хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ сард хүний нөөц сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 1, хуяглан хүргэх офицер 1, тогооч 1 томилогдон тоо бүртгэлийн туслах 1 дадлагжигч ажилтан жинхэлсэн байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж ажиллаж ирсний зэрэгцээ 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг хичээл сургалт жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна.

Шинээр баригдах Цагдан хорих байр болон конторын барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 23 ялтанг барилгын туслах ажилтнаар ажиллуулах гэрээ байгуулан ажиллууж байна. Барилгын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан 2017 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 17:00 цагаас өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин нийт бие бүрэлдэхүүнийг албаны бэлэн байдал хангуулах зорилгоор Түгшүүр-1 дохиогоор дуудаж бэлэн байдлыг шалгахад хоцорсон болон утас нь холбогдоогүй алба хаагч байхгүй байлаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хорих ангийн даргын зөвлөлийн гишүүд, шуурхай бүлгийн 14 алба хаагч ангийн байрлалд байрлаж ажилласан бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдлыг 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 18:00 цагт цуцалж хорих анги ердийн хамгаалалтанд шилжсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээний дагуу хуваарьт өдрүүдэд тус албанаас 4 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан.

Хорих ангийн харуул хамгаалалтыг "Хорих ангийн харуул хамгаалалт болон ялтанд хяналт тавих журам"-ын дагуу ажиллуулсан ба албаны даргын тушаалаар онцгой нөхцөлийн үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавин ажиллав.

Ангийн байрлалаас 800м-т байрлах малын хэсэгт 1 хянагчийн хяналтанд нэр бүхий 3 ялтныг ажиллуулж, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу шалган нэмэлт үүрэг даалгавраар ханган тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба - Хорих 457 дугаар ангийн үйл ажиллагаа хууль журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд ялтан, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Улсын бүртгэлийн хэлтэс: Энэ сард нийт 2287 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас иргэний бүртгэлийн чиглэлээр 1550, Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, гадаад паспорт олголт болон сунгалт 462, иргэний үнэмлэх шинээр олгосон 133, сунгалт 101, дахин олгосон 132, иргэний бүртгэлийн лавлагаа 440 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 282 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 630, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 107 иргэнд холбогдох үйлчилгээг тус тус үзүүлж ажиллав.

Иргэдээс нийт 19 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 11 хуулийн хугацаанд шийдвэрлэж, 8 өргөдлийн хугацаа болоогүй ба шийдвэрлэгдэх шатандаа байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн газрын НЭМХ-ийн дарга, Өсвөр үе ирээдүй босго төвийн эмч, ХШҮ хариуцсан мэргэжилтэн, Мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нар Норвегийн тусламжийн байгууллагын ЭМАШТҮБ-2 төслийн санхүүжилтээр 2017 оны 06 сарын 3-6-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд зохион байгуулагдсан “Амны хөндийн үзлэг хийх арга зүй” сэдэвт бүсийн зөвлөлдөх сургалтанд хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн. Эдгээр сурагч багш нар 2017 оны 9 сард сургууль, цэцэрлэгийн бүх эмч нарт сургалт зохион байгуулж чадавхижуулан хүүхдийн амны хөндийн үзлэг хийж, амны хөндийн өвчлөлийн судалгаа гарган эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөөд байна.

Булган, Үенч, Алтай сумын эрүүл мэндийн төвүүдийн НҮБХАС-ийн хүүхдийн сангийн төслийн санхүүжилтээр олон найрлагат бичил тэжээл олгогдсон байдалд хяналт үнэлгээ хийж арга зүйн зөвлөгөө өгөв. Мөн багийн эмч нарын 2 дугаар ээлжийн сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу НТБ-ын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх 2 төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгууллаа.

2011 оны Эрүүл мэндийн сайдын 122 дугаар тушаалын дагуу вакцины хөргөгчний хэмийг өглөө, орой өдөрт 2 удаа харж тэмдэглэн, хадгалалтын үеийн аюулгүй байдлыг чанд баримтлан ажилласан. 5 сарын дархлаажуулалтын хамралтын болон зарцуулалтын мэдээг анхан шатны нэгжүүдээс авч, нэгтгэн тайланг хугацаанд нь Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн дархлаажуулалтын төвд хүргүүлсэн.

Зооноз судлалын үндэсний төвөөс хуваарилагдан ирсэн 3000 хүн тун тарваган тахал өвчний эсрэг вакциныг тарваган тахлын голомт бүхий 13 суманд хуваарилан хүргүүлж байна. 3 дугаар улиралд шаардлагатай 42,739, 419,50 үнэ бүхий вакцин, дагалдах хэрэгслийг Халдварт өвчин судлалын Үндэсний төвөөс захиалан авч, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн амаржих газар, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэхэд бэлэн болгов.

Нохойнд уруулж ноцуулсан 6 хүнийг галзуу өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулж галзуу өвчнөөс урьдчилан сэргийлж ажиллалаа.

Халдварт өвчний сарын мэдээг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс авч, <http://103.17.109.29:1441/> цахим сайтад байршуулж, бааз үүсгэв. Томуу, томуу төст өвчний мэдээг 4 долоо хоног бүр 6 өрх, 16 сумын эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс авч нэгтгэн 7 хоногийн Мягмар гараг бүр Томуугийн үндэсний төвийн <http://fis.flu.mn/> цахим хаягаар нэвтрэн мэдээллээ хугацаанд нь оруулж ажиллалаа. Цочмог тууралттай, халууралттай хам шинж -11, Цочмог цэврүүт тууралттай, халууралттай хам шинж -9 өвчлөлийг EWAR 2.0 программд шивж бааз үүсгэн, үүсгэсэн баазыг Халдварт өвчний Үндэсний төвийн тандалтын албанд мэдээлэв.

Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 13-ны А/18 дугаар тушаалаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт

эрчимжүүлэх, эмч мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй хамт батлуулан, ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж, цаашид хийгдэх ажлуудын талаар болон хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар эмч, ажилчдад аймгийн Эрүүл мэндийн газраас үүрэг болгов.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторийн тасгийн эрхлэгч их эмчтэй хамтран 16 сумын Эрүүл мэндийн төвүүдийн лаборант нарт элэгний В, С вирусийн халдварыг илрүүлэх хурдавчилсан оношлуураар шинжилгээ хийх аргачлал, сорьц тээвэрлэлтийн талаар сургалт хийсэн. Сургалтын дараа элэгний В, С вирусын халдварыг илрүүлэх хурдавчилсан 8000 оношлуурыг 16 сумын Эрүүл мэндийн төвүүдэд тараан өгч, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хепатит В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамрагдсан 40-65 насны иргэдийн мэдээг авч эхэлснээр илрүүлэг шинжилгээ 29,6 хувьтай байна.

НҮБ-ын ХАС-ын шадар суурин төлөөлөгч Ш.Илизагаар ахлуулсан ажлын хэсэг аймгийн Эрүүл мэндийн газар болон БОЭТ-ийн Амаржих газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, Амаржих газарт өмнө нь ХАС-аас ирүүлсэн багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтанд хяналт, үнэлгээ хийх болон шинээр 2 жилийн хугацаанд хэрэгжих “Эх, хүүхдийн эрүүл мэнд” төслийн хүрээнд зайн сургалтанд хамрагдах нөхцөл боломжийг судлах, телемедициний оношлогоо, эмчилгээний сургалтанд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хэрхэн оролцох талаар тус тус мэдээлэл өгч, цаашид хэрхэн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар харилцан санал солилцлоо.

Эрүүл мэндийн яамнаас 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” стратегийн аймгийн дэд хөтөлбөрт Эрүүл мэндийн яам болон сум, өрхийн эрүүл мэндийн төв, бусад хамтрагч байгууллагуудаас санал авч нэгтгэн, аймгийн Засаг даргаар батлуулахаар бэлэн болгоод байна.

Азийн хөгжлийн банкны “Улсын эмнэлэгт боломжийн үнэтэй эмийн хангамж хүртээмжийг сайжруулах” техник туслалцааны /8967-МОН/ төслийн хүрээнд ерөнхий гэрээгээр худалдан авах 20 нэр төрлийн эмийн нэрсийг БОЭТ-ийн Эм зүйн албатай хэлэлцэн Эрүүл мэндийн яамны эм үйлдвэрлэл, технологийн газарт хүргүүлэв. “Ховд аймгийн хүн амын дундах антибиотикийн хэрэглээг тодорхойлох нь” судалгааг SPSS 22.0 программ дээр шивж дууссан ба одоогоор судалгааны нэгдсэн үр дүнг гаргахад бэлэн болов.

2017 онд Магадлан итгэмжлэлд орох эрүүл мэндийн байгууллагуудад холбогдох материалаа яаралтай бүрдүүлж ирүүлэх тухай албан тоотыг хүргүүлж, Булган өрхийн эрүүл мэндийн төв, Зэрэг сумын материалыг хүлээн аваад байна. Эрүүл мэндийн яаманд “Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын өнөөгийн байдал” судалгааны асуумжаар 16 сум, 6 өрх, БОЭТ-өөс судалгаа авч нэгтгэж явуулсан.

Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн газарт “Сувилахуйн дагнасан төвийн ажиллах журам” тушаалын төслийг БОЭТ-ийн сувिलाхуйн албаар хэлэлцүүлж хариуг хүргүүлэв. “Түнхний үений дутуу хөгжилтэй нярайд хийгдэх асаргаа сувилгаа” сэдэвт сургалтанд оролцох сувилал, эх баригч нарын мэдээллийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлээд байна.

2017 оны 05-р сарын төсвийн гүйцэтгэлийн болон өр авлагын мэдээг байгууллага бүрээр хүлээн авч нэгтгэн Эрүүл мэндийн яам, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүллээ. 05-р сарын байдлаар 5884,4 сая төгрөгийн эх үүсвэрээр 5687,7 сая төгрөгийн урсгал зардалд зарцуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 196,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 56.8 сая төгрөгийн авлагатай, 120.4 сая төгрөгийн өглөгтэй байна. Үүний 80.2 сая төгрөг буюу 66.6 хувь нь эмийн өглөг, 12.3 сая буюу 10.2 хувь нь түлш

халаалтын зардлын өглөг, 12,1 сая төгрөг буюу 10,0 хувь нь цалин, НДШ–ийн өглөг, нийт өглөгийн 10,8 сая төгрөг буюу 8,9 хувь нь БОЭТ-ийн өглөг, 61,8 сая төгрөг буюу 51,3 хувь нь сумдын ЭМТ, 25,8 сая төгрөг буюу 21,4 хувь нь Булган сумын нэгдсэн эмнэлгийн өглөгүүд байна. Байгууллагуудын өглөг үүсч байгаа шалтгааныг тодруулан цаашид авах арга хэмжээний талаар албан тоотоор хүргүүлэв.

Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангахтай холбоотой түргэн тусламжийн машины хангалт, барилгын засвар, урсгал зардлын тооцоог байгууллага нэг бүрээр авч Эрүүл мэндийн яаманд хүргүүллээ. Яамны хөрөнгө оруулалтаар 8 сумын эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн машин хүлээн авсан актыг холбогдох бичиг баримтын хамт яамны хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүллээ. 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллийг маягтын дагуу боловсруулан төсөв ирүүлэх хуваарийн хамт байгууллагуудад хүргүүллээ.

Цэцэг, Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад сумын эрүүл мэндийн төвийн автомашиныг шинэчилснээр сумын Эрүүл мэндийн төвүүд түргэн тусламжийг цаг алдахгүй хүргэх боломж бүрдэж байна.

Эрүүл мэндийн газрын барилгын засварын ажлын гүйцэтгэгчээр “Ховд баганат” ХХК шалгарч төсөвт заагдсан ажлаа дуусч хүлээж авах хүсэлт ирүүлсний дагуу аймгийн холбогдох хэлтсийн мэргэжилтэн, байгууллагын мэргэжилтнүүдийн хамт ажлын гүйцэтгэлтэй танилцаж зарим ажлуудыг хийж хүлээж авахаар боллоо.

АШУҮИС үүсгэн байгуулагдсаны 75 жилийн ойн хүрээнд тус сургуулийг болон харъяа сургуулийг төгсөгчдийн “Багш шавийн эрдмийн уулзалт-2017”, “Эмнэлзүйн шинжлэх ухааны хөгжилд–Эрдэм судлалын гүйцэтгэх үүрэг” сэдэвт 2 кредитийн сургалтыг амжилттай зохион байгуулж нийт 400 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа. 2017 оны 7,8 дугаар сард хугацаа нь дуусаж байгаа багц цагаа биелүүлсэн 36 эмч мэргэжилтний холбогдох материалыг бүрдүүлэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн болно. Мөн 4, 5, 6 сард хугацаа нь дуусаж сунгуулсан эмч мэргэжилтнүүдийн эмчлэх, сувилах эрхийн гэрчилгээ Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс тус тус хүлээн авлаа. Булган сумын нэгдсэн эмнэлэг, Чандмань, Цэцэг сумдын эрүүл мэндийн төвийн 80 жилийн ойг тохиолдуулан Засгийн газрын болон яамны холбогдох шагналаар шагнуулах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалыг Эрүүл мэндийн яамны төрийн захиргаа удирдлагын газарт тус тус холбогдох журмын дагуу хүргүүллээ.

Хяналт-шинжилгээ үнэлгээний 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Булган сумын нэгдсэн эмнэлэг, Алтай, Үенч, Дуут сумдын эрүүл мэндийн төв, Ач заяа, Элбэрэлт бүжин лхам, Ачлалт наран хайрхан, Очирсүлд, Жаргалант удам, Энхрий Жаргалант, Сэтэр хүрэн, Сувдан шигтгээ, Ариун шүд, Хаш гэрэлт, Эх үр, Ач үрийн заяа, Мөнгөн морьт, Ач Оюундалай хувийн хэвшлийн эмнэлгүүдэд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлэв.

2016 онд “Хүүхдийн өвчлөл, эндэгдэл өндөр байсан Булган сумын нэгдсэн эмнэлэг болон Алтай сумын эрүүл мэндийн төвүүдэд эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр ХШҮ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хүүхдийн эндэгдлийн талаар уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав.

Мөн Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээний Маралжин, Хишигбүрэн, Ачит алтан хундага, Алтан агь энх, Нандин тун, Шимт ганга, Хос шүүдэргэнэ, Вансэмбэрүү 1, Вансэмбэрүү-2, Хан хөхий эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагуудад дэмжлэгт хяналт үнэлгээг хийж, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг үнэлж зөвлөмж өгөв. Эмийн хангалт дээд тал нь 93% байсан бол доод тал нь 54%-тай, дундаж нь 70%-ийн үзүүлэлтэй байна.

Тус ажлын хүрээнд Зөвлөмж боловсруулан эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд, эмийн сангийн үйл ажиллагаа, тухайн сумын болон хувийн хэвшлийн ортой оргүй эмнэлгүүд, эмийн сангийн стандартын хангалт тус бүрээр багцлан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэв. Хяналт үнэлгээний үеэр тухайн сум орон нутгийн удирдлагууд болон бусад холбогдох албан тушаалтнуудыг урьж оролцуулан, эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж буй ажлууд, тулгамдаж буй асуудлуудын талаар харилцан ярилцаж, сум орон нутгийн түвшинд удирдлагын дэмжлэгийг авах, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахаар шийдвэрлэлээ.

Сарын шуурхай мэдээний дагуу харьяа Эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн дүгнэлт хийж, үндсэн үзүүлэлт тоо баримтаар тасралтгүй хангаж хугацаанд нь Эрүүл мэндийн хөгжлийн төв болон аймгийн Статистикийн хэлтэст цахим, цаасан хэлбэрээр хүргүүлэв. ЭХЭМҮТ-н тандалт судалгааны албанд 24, 25 дахь 7 хоног бүрийн мэдээг Эрүүл мэндийн 23 байгууллагаас авч тухай бүр нь мэдээлэв. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвийн 40-65 насны хүн амын үзлэг, шинжилгээний мэдээллийг ELEGBUTEN.MOHS.MN програмд шивж, нийт 1959 хүн шивэлтэнд орж одоогийн байдлаар 10,2 хувь нь хамрагдсан байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Монгол улсын их хурлын тогтоол, хэрэгжилтийн явцын тухай танилцуулга, мэдээлэл сургалт сурталчилгааны тайлан, үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар, Эрүүл мэндийн газраас 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, стратегүүдийн тайлан болон хөтөлбөрүүдийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэж Эрүүл мэндийн яам болон аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдэд хүргүүлэв.

Мөн байгууллагын веб сайтыг khovdeng.mohs.mn хаягаар шинэчлэн, холбогдох цэсүүдийг үүсгэн, баяжилт хийгдээд байна. Байгууллагын цахим хуудсан дахь групп болон facebook /page/ хуудсанд цаг үеийн талаарх болон сургалт, сурталчилгаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл, зар сэрэмжлүүлэг байршууллаа. Мөн байгууллагын гадна хаяг, самбарын эхийг бэлтгэж, байгууллагын гадна камер суурилуулав.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Монгол бөхөнд бог малд дэгдсэн мялзан өвчнийг хэлэлцэх олон улсын шинжээчдийн уулзалт 2017 оны 05 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд Нэгдсэн Үндэсний Байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгууллаа. Сургалтын үйл ажиллагааг нээж НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын суурийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч Аднан Куэрэши, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Ц.Батбаяр нар нээж үг хэлсэн бөгөөд үндсэн илтгэлийг НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын, Дэлхийн мал амьтаны эрүүл мэндийн байгууллагын бог малын мялзан өвчин /БММӨ/ асуудал хариуцсан нарийн бичиг Феликс Жейми “Монгол дахь БММӨ-ий нөхцөл байдал, БММӨ-ний илрүүлэлт, ялган оношилгооны талаар тавьсан болно.

Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан Бичил уурхай эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн Булган суманд 6-р сарын 16-нд зохион байгуулагдаж Бичил уурхай эрхлэгч иргэд болон төрийн албан хаагчид оролцож бичил уурхайн өнөөгийн нөхцөл байдал, хүний эрх зөрчигдөж буй талаар хамтран ярилцаж мөрдөгдөж буй хууль тогтоомжийн талаар мэдээлэл авсан болно.

Де Нэйчэ консерванси олон улсын байгууллагаас хийж буй экологийн бүс нутгийн үнэлгээгээр тус аймагт хэд хэдэн газар экологийн онцгой ач холбогдолтой зайлшгүй хамгаалалтад авах шаардлагатай газар сонгогдсон.

Ховд аймгийн Экологийн бүс нутгийн үнэлгээгээр сонгогдсон онцгой ач холбогдолтой 10 газрын 19878,4 га талбай эзэлж байгаа бөгөөд улсын тусгай хамгаалалтад Сутай хайрхан, Булган гол-Их Онгог байгалын цогцолбор газар /БЦГ/, Говийн Их Дархан Цаазат газар /ГИДЦГ/-ын Б хэсгийн өргөтгөлийг улсын тусгай хамгаалалтанд оруулахаар Засгийн газарт өргөн мэдүүлсэн бөгөөд шинээр сонгогдсон газруудаас Ховд гол-Сартугтайн гууг орон нутгийн хамгаалалтад авахаар Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын 2017 оны 04 тоот тогтоол, мөн Мянгад сумын ИТХ-ын 04 тоот тогтоолуудыг гаргаж Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст хүргүүлээ. Цэцэг сумын Хажинга, Мөст сумын Баатарын нуруу, Дуут сумын Тэрэгт, Давст уул, Мөнххайрхан сумын Борт, Булган, Үенч, Алтай, Зэрэг сумдаар явж орон нутгийн тусгай хамгаалалтанд оруулах газрын солбилцолыг тогтоох ажлаар аймгийн Газрын харьцаа барилга хот байгууллалтын газартай хамтран ажиллаа.

Олон улсын тахь групп /ОУТГ/ нь Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран байгуулсан гэрээний дагуу тахийг уугуул эх нутагт нь буюу ГИДЦГ-ын Б хэсэг, Тахийн тал, Тахийн усанд сэргээн нутагшуулах төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд 2017 оны 6 дугаар сарын 20 нд ОУТГ, Чехийн амьтны хүрээлэнтэй хамтран 4 тахийн гүүг Булган суманд CASA онгоцоор тээвэрлэн ирж ГИДЦГ-ын Б хэсэг Тахийн талд нутагшууллаа. Энэхүү үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга болон албаны хүмүүс оролцлоо.

Манай аймаг нь аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар байгаль, түүх, соёлын нөөцийг хадгалах, хойч үедээ сурталчлан таниулах, улмаар орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, нутгийн иргэдийн амжиргааг дээшлүүлэх, аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд Монголдоо төдийгүй дэлхийд алдартай Гурван Сэнхэрийн агуйгаа аялал жуулчлалын зорих газар болгон тохижуулж, түүнээс салаалсан 5 чиглэлийн аяллын маршрутыг бий болгон аялал жуулчлалыг хөгжүүлэхээр зорин ажиллаж байгаатай холбоотой аймгийн хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд хөндлөнгийн шинжээчдийн багийг ажилуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр 2017 оны 6-р сарын 20-25-ны өдрүүдэд шинжээчдийн баг Ховд аймагт ажиллаж аялал жуулчлалын салбарыхан, аялал жуулчлалын гол гол үзмэрүүдтэй танилцлаа.

Дэлхийн байгаль орчны өдрийг тохиолдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтайн бүсийн салбарын санхүүгийн дэмжлэгтэйгээр орон нутгаа сурталчлах, Ховд аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар байгаль, түүх, соёлын нөөцийг хадгалах, хойч үедээ сурталчлан таниулах, жуулчдын тоог нэмэгдүүлж аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн нисэх буудал дээр цахим мэдээллийн киокс, сурталчилгааны цахим самбаруудыг байрлууллаа.

Киокс байрлуулсны ач холбогдол нь иргэд мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах, аялал жуулчлалын зорих газруудын мэдээллийг авснаар сүүлийн үед хүчээ авч байгаа дотоодын аялал жуулчлал хөгжих боломжийг олгож байгаа юм. Мөн дэлхий нийтийн асуудал болоод байгаа ногоон хөгжлийн үзэл баримтлал, байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, иргэдэд экологийн боловсрол олгох зорилгоор давхар агуулж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын батласан удирдамжын дагуу 2017 оны 06 дугаар сарын 18-22-ний өдрүүдэд Алтай, Булган, Үенч, Мөст, Цэцэг, Зэрэг, Манхан сумдад ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. Тус удирдамжын хүрээнд сумуудын усны чиглэлээр хийх хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй

асуудлуудтай танилцаж, Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 6 дугаар сарын 05-ний өдрийн А/230-127 дугаар тушаалаар хамтарсан баталсан “Усан сан бүхий газрын энгийн онцгой, эрүүл ахуй хаммгаалалтын журам”-ын талаар мэдээлэл хийж жил бүр гадаргын болон гүний усны тооллогыг чанартай хийж байхыг анхаарууллаа.

2017 оны 06 сарын 12-ний өдөр Бадамлах Дөл ХХК Ус ашиглуулах зөвшөөрл, 2017 оны 06 сарын 13-ний өдөр Чайна- Хуаши ХХК-ий Ус ашиглуулах зөвшөөрлийг олгож гэрээ байгууллаа.

Олон Улсны цөлжилтийн өдрийг угтаж 6 дугаар сарын 5, 15-ны өдрүүдэд Буянт гол дагуу нийтийн цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 150 гаруй хүн 8 машин хог түүж хогийн нэгдсэн цэгт ачуулсан. Буянт голын хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах чиглэлээр эко бие засах газрыг тохижуулаад байна.

Швейцарын хөгжлийн агентлагын “Тогтвортой бичил уурхай” төсөл орон нутгийн байгууллагуудтай хамтран Алтай, Булган, Үенч, Цэцэг, Мөст, Дөргөн сумуудад хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтанд оруулах талаар сургалтыг зохион байгуулж иргэдийг мэдээллээр хангалаа. Тус сургалтанд нийт 400 гаруй иргэд хамрагдсан бөгөөд төслийн хүрээнд дээрх сумуудад хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн судалгааг гаргаж, цаашид бичил уурхай эрхлэгчдийг зохион байгуулалтанд ороход дэмжлэг үзүүлэх юм.

2017 оны 06 дугаар сарын 18-22-ний өдрүүдэд Алтай, Булган, Үенч, Мөст, Цэцэг, Зэрэг, Манхан сумдад ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. Тус удирдамжын хүрээнд сумуудын газрын хэвлий түүний баялагийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудлуудтай танилцаж, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн А/71 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого хийх” ажлын удирдамжыг танилцуулан мэдээллээр хангалаа.

Дээрх сумууд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин төлбөрийн орлогыг орон нутгийн дансанд төвлөрүүлэх Алтай, Булган, Цэцэг сумдад гарсан хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагааг тухай бүрт таслан зогсоож, хуулийг сурталчилан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Алтай сумын Бодонч багийн нутаг Таригт хууль бус ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож, хууль журмыг сурталчилан мэдээллээр ханган ажиллалаа.

Цэцэг сумын Баян-Овоо багийн Цагаан эрэгт нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж буй “Өгөөжтэй өв” ХХК, нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй “Хамтын хүч” нөхөрлөл, Хүрэн толгойд хайгуулын ажил хийж буй “Монгол цамхаг” ХХК-ны үйл ажиллагаанд тус сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулиуд болон холбогдох дүрэм журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулах зориолгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар дээрх аж ахуйн нэгж байгууллагын ашиглаж буй эксковатор, ковш, генераторыг лацдаж үйл ажиллагааг зогсоолоо.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Бог малын мялзан өвчинтэй тэмцэх олон улсын шинжээчдийн, Паталогийн задлан шинжилгээний сургалтуудад холбогдох эмч

мэргэжилтнүүдийг хамруулж, алба хаагчдыг сурах боломжоор удирдлагын зүгээс дэмжиж ажиллав.

Монголын мал эмнэлгийн холбооноос зохион байгуулсан Малын эмч нарын эм барих итгэмжлэлийн сургалтад 8 сумын 5 нэгжийн эмч нар хамрагдан эм барих эрхээ 5 жилээр сунгав.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 153.6 мянган толгой бод, 291.6 мянган толгой бог мал нийт 1445.2 мянган толгой малыг урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээнд хамруулахаас 1.230,0 мянган толгой мал хамрагдаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээ 88,1 хувьтай байна.

Дарви сумын Булаг багийн малчин Ш.Элбэгийн суурьт бог малын мялзан өвчин гарсан нь оношлогоогоор нотлогдсон тул халдвар тархахаас сэргийлж сумын Засаг даргын 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн захирамжаар 2 ажлын хэсэг томилогдон голомтот бүсийн 60 өрхийн 6094 хурга, 3786 ишиг нийт 9880 төл малд мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийж дархлаажууллаа.

Шүлхий, бог малын мялзан өвчнийг тандах шинжилгээнд дээж авах ажлын удирдамж боловсруулж, шаардагдах зардлыг хуваарилан ХХААГ-ын даргын 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн А/15 тоот тушаалаар 2 ажлын хэсэг гарч, Алтай, Булган, Үенч, Зэрэг, Мянгад сумдын 10 багийн 30 өрхийн 150 үхэр, 150 хонь, 150 ямаа, 60 тэмээ нийт 510 малаас цусны дээж авч, ийлдсийг ялган шинжилгээ хийхэд бэлэн болгоод байна.

Мон Вет Мед компаниас тендерээр тус лабораторид нийлүүлсэн 9,5 сая төгрөгийн үнэ бүхий оношлуур, урвалж бодис, лабораторийн хэрэглэгдхүүнийг хүлээн авч орлого зарлагын баримтыг бүрдүүлэн хүргүүллээ.

Мянгад сумын Баянбулаг багаас ирүүлсэн цусны ийлдэс 6 ширхэг, эмгэгт эд 2 ширхэг /уушиг, зүрх/ , Дарви сумын Дэлгэр багаас ирүүлсэн хурга, ямааны эмгэгт материал, Ховд сумын Баянбулаг багаас ирүүлсэн ишигний эмгэгт эдийн дээж, Мянгад сумын Цагаан булан багийн тугалын эдийн дээж, Чандмань сумын Жаргалан багийн хонины эдийн дээжинд нян судлалын оношлох шинжилгээ хийж, шинжилгээгээр Дарви, Ховд сумын дээжинд колибактериоз өвчин, Мянгад сумын Баянбулаг багийн малын дээжинд стафилококк илэрсэн.

Мөн Хан орд хүнсний захад худалдаалагдаж байгаа 4440 кг махны 120 дээж, 1180 л сүүний 66 дээж, арьсны 700, ноолуурын 1000, өлөнгийн 1000ш гогцоонд МЭАЦ-н шинжилгээ хийж, 350 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийв.

2017 оны 5 дугаар сарын 18-наас 6 дугаар сарын 6-ны хооронд БНХАУ-ын Шансы мужийн Янлин хотноо зохион байгуулагдсан “Хонь, ямааны эрчимжсэн аж ахуйн үржлийн ажлыг сайжруулах нь” сэдэвт сургалтанд 8 орны мал аж ахуйн мэргэжилтэн, малын эмч нар оролцсон ба манай аймгаас Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн албаны дарга Г.Бат-Өлзий хамрагдав.

Хаврын тариалалт 6 дугаар сарын 10-ны байдлаар үр тариа 187.4га, малын тэжээл 439.6га, төмс 656.4га, хүнсний ногоо 783.4га талбайд, 1,3га талбайд жимс жимсгэнэ тариалаад байна.

“Хувийн хэвшлийг дэмжих” нь аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнийг Дэлхийн зөн ОУБ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудтай хамтран зохион байгуулж, зөвлөгөөнд 150 гаруй бизнес эрхлэгчид оролцов. Уг зөвлөгөөнд ЖДҮХСан, Сум хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сангийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч зөвлөгөөний амжилттай зохион байгуулав.

Зээлийн батлан даалтын сангаас өгсөн зааварчилгааны дагуу 2015 онд батлан даалтанд хамрагдсан “Хатанбуянт констракшн” ХХК-ий үйл ажиллагаанд үнэлгээ хийж хүргүүлсэн. 2017 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан “Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөгчдийн зөвлөлдөх уулзалт-2”

сургалтанд хамрагдаж орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулах үйлдвэрүүдийг цахим програмд шивж мэдээллийн сан үүсгэхээр болоод байна.

Царцааны гаралт, тархалтын тандалт судалгааг 2017 оны 06 дугаар сарын 09-ээс 06 дугаар сарын 15-ыг хүртэлх 7 хоногийн хугацаанд Мөст, Мөнххайрхан, Манхан, Цэцэг, Зэрэг сумдын нутгаар 1046 км маршрутаар Ургамал хамгааллын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шавьж судлалын лабораторийн эрхлэгч Б.Мөнхцэцэг, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн М.Цогт-Эрдэнэ нар хамтран зохион байгуулж, Манхан сумын Ботгон багийн Хавчигийн цагаан хөтөл, Ангиртын бэлчир, Замын цахир, Ганц мод, Үнэгтийн үзүүр, Морьтын хөдөө, Цэцэг сумын Баян овоо багийн Шаврын гол, Намын уулс, Хулман нуур, Баянгол багийн Хонгорын доод овоо, дээд овоо, Шуудуйн гол, Мөст сумын: Давст (Хагийн улаан үзүүр), Тавтын адаг ус, Хайч, Баян булаг, Цагаан хад, Мөнххайрхан сумын Цэнхэр багийн Ендэрт, Дээд, доод улаан говь, улаан эрэг, Борт багийн Хөх нуур, Шуурхай, Тошингийн Их, бага тошин, Зэрэг сумын Цагаан бургас багийн Хонгорын хөтөл, Мөстийн бэл, Бургасан багийн Урд, Хойд адуу гаргадаг газруудаар тодотгох судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Судалгааг 5 сумын нутагт нүдэн баримжаа болон зурваслан шүүрүүлийн арга ашиглан 1м² талбайд байгаа царцааны тоог тогтоосон. Судалгаанд хамрагдсан цэгүүдийн солбицолыг GPS ашиглан тогтоосон ба цаашид царцаатай химийн аргаар тэмцэхээс гадна ягаан тодолын үүр барих, механик аргаар тэмцэх технологи арга ажиллагаа шаардлагатай байна гэсэн саналыг судалгааны баг гаргав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар хамтран царцаатай тэмцэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын 170606/04-082 дугаар гэрээг байгуулж, гэрээний дагуу 30000га бэлчээрт царцаатай тэмцэхэд шаардагдах Карате 5% ургамал хамгааллын шингэн бодис 600 литрийг 5495УНТ улсын дугаартай НҮУНДАI маркийн ачааны авто машины жолооч Н.Гансүх тээвэрлэж ирсэнийг Хүнс хөдөө аж ахуйн газар, аймгийн мэргэжлийн хяналтын ургамал хамгаалал хорио цээрийн улсын байцаагч нар бүрэн хүлээн авлаа.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Жаргалант сумын газар эзэмшлийн нэгж талбарын архивыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд тус сумын 6000 гаруй нэгж талбарын хувийн хэргүүдийг эмхлэн цэгцэлж, цахимд шивж оруулав.

Мянгад сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, малчдын өвөлжөө, хаваржааны газар, худаг уст цэг, хадлангийн газар, нүүдэл болон тууврын зам, ан амьтдын тархац зэргийг ArcGIS программаар боловсруулан Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газарт хүргүүлээ.

Газрын татвар, төлбөрийн орлого 63178950 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Тайлант сард газрын биржийн программд 143 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барьцаа, 29 үнийн мэдээг бүртгэлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг даргаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг гаргаж хугацаанд нь Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэв.

Тайлант хугацаанд нийт 67 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, үүнээс 28 иргэнд баталгаажсан кадастрын зургаар үйлчилэв.

Аймгийн ЗДТГ-ын ХБХОБТХ-ийн даргаар ахлуулсан ажлын хамтарсан баг 2017 оны 6 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байсан болон шинээр хэрэгжүүлэхээр хүсэлтээ ирүүлсэн сургууль, цэцэрлэгийн барилгуудын засварын ажлын гүйцэтгэлтэй танилцаж, Чандмань, Алтай, Үенч, Булган, Цэцэг, Дарви сумдад ажиллалаа. Мөн БХБХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Булган, Манхан, Үенч, Зэрэг сумдад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа

барилгуудын явцтай танилцаж, хяналт хийж гарсан зөрчил дутагдлын талаар холбогдох хүмүүст үүрэг даалгавар өгөв.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хавсралт хүснэгтийн дагуу тооцож холбогдох байгууллагад хүргүүлээ. Жаргалант суманд шинээр баригдаж буй барилгуудад хяналт хийж, эхлэх зөвшөөрөл аваагүйн улмаас ажлыг нь зогсоосон барилгуудын ажилтай танилцаж яаралтай зөвшөөрлөө авч ажлаа үргэлжлүүлэхийг санууллаа. Мөн иргэд, аж ахуйн нэгжээс ирсэн өргөдлийн дагуу ашиглалтад орсон болон баригдаж буй барилгуудын ажилтай танилцаж тавьсан асуудлуудыг шийдвэрлэлээ. Жаргалант сумын 11-р цэцэрлэгийн дулаан техникийн ажилд хяналт хийлээ. Барилгын буулгалтын ажил хийгдэж байв. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны барилга, ЭМГ-ын засвар, 11-р цэцэрлэг, Монгол банкны барилга угсралтын ажлуудад хяналт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид хийсэн шинжилгээний талаар: 6 дугаар сард нийт 5 байгууллагаас 7 төрлийн материал ирүүлсэнээс 10 нэр төрлийн сорилонд шинжилгээ хийсэн. Үүнд: “Од-Цэ” ХХК, “Ховдын тулга” ХХК, “Монголиа бюлдинг консолтинг” ХХК, “Чинээлэг заан” ХХК, Иргэн Д.Тэгшбаяр нараас сорьцоо ирүүлсэн ба хайрганы 2, элсний 2, бетон сорьцийн 1, тоосгоны 2, хөөсөн полисроль хавтан 1, хөнгөн блок 1, өнгөлгөөний тоосго 1 ирэв.

Авто замын талаар: Аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгүүлэхээр хот дотор баригдах хэсэгчилсэн 10 км хатуу хучилттай авто замын маршрут, чиглэлийг тодорхойлон инженерийн нарийвчилсан зураг төсөв боловсруулах, хот доторх явган хүний замыг 3000 метрээр нэмэгдүүлэх, Тавтын хөтлөөр Мөнххайрхан чиглэлийн ердийн хөрсөн замд засвар шинэчлэлтийн ажил гүйцэтгэх, Чандмань сумын чиглэлийн замын ТЭЗҮ боловсруулах зэрэг ажлуудад худалдан авах ажиллагаа зохион байгуулж, зарим төсөл дээр гүйцэтгэгч ажлаа эхлэхэд бэлэн болоод байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд баригдах 4,3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гүйцэтгэгчээр “Түм дэлгэрэх” ХХК шалгараад байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Босоо тэнхлэгийн Ховд-Хашаатын даваа-Толбо сум, Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн хэсэгчилсэн 189.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажил хэвийн үргэлжилж байгаа бөгөөд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Авто замын улсын байцаагч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, тандалт судалгааг 4 удаа хийж гүйцэтгэгчид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллав.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймаг орон нутагт холбогдолтой 183 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 421 арга хэмжээний биелэлтийг тооцож, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2/1596 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Хөтөлбөрт тусгагдсан 421 арга хэмжээний хэрэгжилт 06 дугаар сарын 21-ний байдлаар 42,68 хувийн биелэлттэй байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэлийн аймаг орон нутагт хэрэгжүүлэх нийт 111 шийдвэрийн хүрээн дэх 150 зүйл заалтын хэрэгжилтийг тооцож, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2/1596 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад шивж оруулан баталгаажууллаа. Аймаг орон нутаг

хэрэгжүүлэх 111 шийдвэрийн 150 зүйл заалтын хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар дунджаар 47,6 хувийн биелэлттэй байна.

2017 оны 06 дугаар сарын байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын 24 тогтоол, 6 хуралдааны тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3, Тэргүүлэгчдийн 60 тогтоол хүлээн авч удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Долоо: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 3 дугаар хуралдаан 2017 оны 06 дугаар сарын 28-ний өдөр хуралдаж сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, 2017 оны Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар хэлэлцэн “хангалттай” гэсэн дүгнэлтийг өглөө.

Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, түүвэр судалгаанд хамрагдах албан газар, малчин болон мал бүхий өрхийн судалгааг авч МИД программд шивж, дүн мэдээг нэгтгэн аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэв.

2017 оны зургадугаар сарын байдлаар сумын 12 багийн 122 иргэн, 6 албан газар, аж ахуйн нэгжүүд 12,5га талбайд үр тариа, 56,7га талбайд төмс, 92,5га талбайд хүнсний нарийн ногоо, 5га талбайд малын тэжээлийн ургамал, нийт 59,1га талбайд жимс жимсгэнэ /үүнээс шинээр 1га/ тариалж, сумын нийт дүнгээр 149,2га талбайд төмс хүнсний ногоо тариалаад байна.

Хагас жилийн байдлаар 47146 эх мал төллөхөөс 43046 толгой мал төллөж, 304 толгой төл хорогдож мал төллөлт 91 хувьтай байна.

Мал сүргийг гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ДХХ вакцин 19760 малд, шөвөг ярын вакцин 11400 малд, дуут хавдарын вакцин 5800 толгой малд, сохор доголын вакциныг 32000 толгой малд, цусан халдвартын вакциныг 24500 толгой малд, галзуугийн вакцин 3200 үхэрт, боомын вакциныг 8600 толгой малд, колибациозын вакциныг 16600 богт нийт давхардсан тоогоор 128680 толгой малд хийж, 16,5 мянган толгой малд туулгалт, 7825 бог 762 бодыг мал амьтны паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж, 15тн мах, махан бүтээгдэхүүн 5300л сүү сүүн бүтээгдэхүүнийг мэдрэхүйн болон лабораторийн шинжилгээнд хамруулаад байна.

Газар зохион байгуулалт дэд бүтцийн чиглэлээр: Сумын ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаар 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах мөн газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолыг тус тус батлууллаа.

Засаг даргын захирамжаар 35 иргэн, 3 аж ахуй нэгжид газар эзэмшүүлж, 2 иргэнд газар өмчлөх шийдвэр гаргаж нийт 59 иргэний газрын асуудлыг шийдвэрлэж ажиллаа.

Байгаль орчны чиглэлээр: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллагуудад “Цэвэр сайхан орчинд Цэцэг шиг үрсээ баярлуулъя” уриатай нийт 24 байгууллага 48 хогийн сав байрлууллаа.

Ховд хотын иргэдийн аюулгүй орчин нөхцөлд тав тухтай амьдрах зорилтын хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн Ховд аймаг дахь салбараас санхүүжүүлэн эко бие засах газрыг байршуулан ойр орчимд нь байгаа 27 өрхтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын нийтийг хамарсан ажлыг санхүүжүүлэх төслийн хүрээнд 10 иргэнийг түр ажлын байраар ханган ажилуулж байгаа ба дээрх иргэдээр 2 дугаар дулааны хажууд тарьсан төгөлийг тухай бүр услуулах, Буянт

голын сав дагуу газарт иргэдийн тарьсан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг гүйцэтгэсэн болно.

Алтай сүм: 2017 оны 06 дугаар сарын 06-ий өдөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаан болж, хуралдаанаар 2017 оны төсвийн тодотгол, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, Бичил уурхайн чиглэлээр иргэдээс ирсэн санал гомдол, хүсэлтийг нээлттэй үлдээв.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Эх үрсийн баярын үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөрийн дагуу сумын төв цэнгэлдэх хүрээлэнд ёслол төгөлдөр тэмдэглэв. Тус арга хэмжээний нээлтэнд сумын удирдлагууд, албан байгууллагын дарга эрхлэгч нар оролцож, цэцэрлэгийн багачууд, сургуулийн сурагчдын нэгдсэн урлагийн тоглолт, үндэсний бөхийн барилдаан, гүйлтийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Алдарт эхийн 1 дүгээр одонгоор Тахилт багийн иргэн Д.Оюунбилэг, Бодонч багийн иргэн Н.Буянхишиг, 2 дугаар одонгоор Алтангадас багийн иргэн Б.Сувд-Эрдэнэ, С.Ариунтунгалаг, С.Энхтуяа, Тахилт багийн иргэн Б.Нарантунгалаг, Х.Уранбилэг, Бодонч багийн иргэн У.Чимгээ тус тус шагнагдав.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Билэгдэмбэрэлээр ахлуулсан ажлын хэсэг нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, цаашид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлаа танилцуулж, ажиллах хугацаандаа сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн хурал зохион байгуулж 4 иргэнийг залуу малчдыг малжуулах төсөлд хамруулсан төдийгүй 2 жилийн хугацаатай 4 000 000 сая төгрөгийг олгохоор шийдвэр гаргав.

Хүний эрхийн комиссын гишүүн өргөдөл гомдол, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Б.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг Захиргааны ерөнхий хууль, бусад хууль тогтоомжоор Төрийн албан хаагч, бичил уул уурхай эрхлэгч нарт сургалт зохион байгуулав.

2017 оны эхний хагас жилийн байдлаар хонь–56669, ямаа–114708, үхэр–11179, адуу–7758, тэмээ–1138 тус тус тоологдсон ба 2016 оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад 39224 тоо толгойгоор өсөж, нийт 191452 тоо толгойд хүрч өссөн дүнтэй байна.

Аймаг, бүсийн уралдаан тэмцээн болон сургуулийн эцэг эх, багшийн холбоо буюу СЭЭБХ-ээс “Би ийм сургуулийг хүсдэг” зохион бичлэг, гар зургийн уралдааныг амжилттай зохион байгуулж шагналт байр эзэлсэн сурагчдыг шагнаж урамшууллаа. Аймгийн хэмжээнд ЕБС-ийн сурагчдын дунд зохиогдсон “Миний гэр бүл ийм л байгаасай” гар зураг, зохион бичлэгийн уралдаанд амжилт гаргасан сурагчдад сумын удирдлагууд шагнал гардуулав.

2017 оны 06 дугаар сарын 26 өдөр Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг амжилттай зохион байгуулж нэр дэвшигч М.Энхболд 662 санал буюу 45,9, Х.Баттулга 417 санал буюу 30,4 хувь, С.Ганбаатар 315 санал буюу 22 хувийн санал тус тус авсан байна.

Дөргөн сүм: 2017 оны 06 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд малчдын уулзалт зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулж, 250 гаруй малчин иргэд хамрагдлаа. Зөвлөгөөнөөр сумын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хагас жилийн биелэлт, төрөөс малчдын талаар баримталж буй бодлого, цаашид хийх ажил, тус суманд зонхилон гардаг малын халдварт өвчин, түүнээс сэргийлэх арга зам, аймаг сумын малчин шалгаруулах журам, малын даатгалын тухай ойлголтуудаар мэдээлэл өгч харилцан ярилцаж санал бодлоо солилцлоо.

Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурал болж, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 3 залуу малчныг сонгон малжуулах хөтөлбөрт хамруулахаар шийдвэр гаргав.

Durgun.khovd.gov.mn албан ёсны веб сайтыг нээн ажиллуулж, ингэснээр суманд болж байгаа үйл явдал, мэдээ мэдээллийг цаг алдалгүй шуурхай ард иргэдэд хүргэх боломж бүрдлээ.

Сумын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хагас жилийн биелэлтийг тооцож аймгийн Засаг даргын Тамгын газарт албажуулж хүргүүлэв.

Иргэдэд төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчилах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах, хугацаанд нь шийдвэрлэх, төрийн үйлчилгээг түргэн шуурхай нэг дороос хүргэх зорилгоор сумын ЗДТГ, төсөвт байгууллагууд хамтран “Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, иргэд хөдөлмөрчдөд хийж хэрэгжүүлж байгаа ажлын тайлан мэдээг танилцуулж, гарын авлага тараах материал, эрүүл мэндийн, иргэний бүртгэлийн, эрүүл мэнд нийгмийн даатгалын, нотариатын, халамж үйлчилгээний болон бусад чиглэлийн үйлчилгээг 100 гаруй иргэдэд үзүүлэв. Энэ үеэр технологийн багш нарын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчлан таниуллаа.

Засгийн газрын тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, өргөдөл, албан бичгийг хүлээн авч шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллав.

Дэлхийн тамхигүй өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд өглөөлөг, сургалт сурталчилгааны ажлыг “Тамхинд үгүй гэж хэлье” уриатайгаар зохион байгуулсан ба 70 гаруй иргэд хамрагдав. Улс орны ирээдүй болсон хүүхэд багачуудыг баярлуулах нэг өдрийг аз жаргалтай инээд хөөртэй өнгөрүүлэхэд төрийн байгууллагууд хамтран Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр буухиа тэмцээн, мөлхөө жаал, дугуйн уралдаан, гар бөмбөг, гүйлт, сагсан бөмбөгийн тэмцээн, үндэсний бөхийн барилдаан зэрэг сдорт урлагийн арга хэмжээг зохион байгууллаа

Мал тооллогын хагас жилийн судалгаанд 95 өрхийг хамруулж, тархалтын дүнгээр хагас жилийн байдлаар 19487 толгой мал тоологдов. Малын хорогдлын болон төл бойжилтын мэдээг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Нийт 48586 эх мал төллөсөнөөс 482 төл хорогдож, 48104 төл бойжиж байна. Отрын нүүдлээр явахдаа баг хариуцсан малын эмчдээ мэдэгдэж малдаа эрүүл мэндийн үзлэг хийлгэж тодорхойлолт гаргуулж байх талаар мэдэгдэл гаргасан ба Агваш, Сээр, Аргалант багийн 80 гаруй малчин өрхийн малд үзлэг хийж эрүүл мэндийн тодорхойлолт өгөв.

Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу тусгай зөвшөөрөлтэй хүнс, барааны дэлгүүр, цайны газруудад хяналт шалгалт хийж шалгалтаар ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй болно.

Эхний хагас жилийн байдлаар Орон нутгийн төсөвт нийт 10 594 000 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 27 345 579 төгрөг төвлөрүүлж 258,1 хувиар, аймгийн төвлөрсөн төсөвт нийт 85514400 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 111338895 төгрөг төвлөрүүлж 130,2 хувиар, улсын төвлөрсөн төсөвт нийт 58087200 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 63601173 төгрөг төвлөрүүлж 109,5 хувиар тус тус биелүүлж ажиллав.

Нийт дүнгээр төсөвт 154195600 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 202285648 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 131,2 биелүүлсэн.

2017 оны 06 сард 343 тэтгэвэр авагчдад 9010000 төгрөгийн санхүүжилтээр тэтгэвэр тавьж олгосон ба өндөр насны тэтгэвэр авагч 245, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 34, тахир дутуугийн тэтгэвэр авагч 64, шинээр 2 иргэнд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан тэтгэвэр тогтоов.

Шинээр 2 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж, нийтдээ 65 даатгуулагчийн 6761,0 төгрөгийн шимтгэл төвлөрүүлж, эрүүл мэндийн даатгалд 70 хүний 3373,000 төгрөгийн шимтгэлийн орлого, тэтгэмжийн даатгалын сангаас 4 эхэд 3910,000 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, 3 өндөр насны тэтгэвэр авагчид 3000,000

төгрөгийн, 1 иргэнд 33599 төгрөгийн хөдөлмөрийн чадвар алдагчийн тэтгэмжийг тус тус олгов.

Тайлант сард 8 төрлийн бүртгэлээр төрөлт-32, нас баралт-6, үрчлэлт-2, овог нэр өөрчлөлт-1, эцэг тогтоолт-1, гэрлэлт-8, шилжиж ирсэн 10, шилжиж явсан-17 иргэний үнэмлэх шинээр захиалсан ба 25, 45 насны сунгалт -35, цахим үнэмлэх 15 иргэнд захиалж, 55 гадаад паспорт, 48 гадаад паспортын сунгалт, 18 иргэний эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн материал хүлээн авч, аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэн гэрчилгээг гаргуулахад бэлэн болгоод байна.

Нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэврийг 40 хүнд 28 сая, ахмад настны асаргааны тэтгэмжийг 65 хүнд 20.8 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааны тэтгэмжийг 14 хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэврийг 14, улиралд олгох тэтгэмжийг 14 иргэнд 5.8 сая, тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг 14 иргэнд 11.2 сая, алдарт эхийн 1 дүгээ одонтой эхийн тэтгэмж 146 эхэд 29.2 сая, 2 дугаар одонтой эхийн тэтгэмж 248 эхэд 24.8 сая төгрөгийг тус тус олгов. 2017 онд шинээр алдарт эхийн 1 дүгээр одон 3, 2 дугаар одон 11 эхэд олгож бүртгэв.

Ахмад настны эмчилгээ сувилгааны унааны хөнгөлөлтийг 6 иргэнд 0.9 сая төгрөг, шүд хийлгэсэн ахмад настанд 120 000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнд 0,3 сая төгрөгийн унааны зардал олгов.

Сумын хэмжээгээр хагас жилийн байдлаар 10 хүн ажилд шинээр орж, 13 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгэгдсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Халамжаас хөдөлмөрт” уриатай нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, нийтдээ 90 гаруй иргэнд мэдээлэл өгч иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгөв.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан иргэн, аж ахуйн нэгжид газар өмчлүүлж эзэмшүүлсэн 1, 2017 онд өмчлөлөө салгуулахыг хүссэн 1 тус тус өргөдөлийг хүлээн авч, нэгж талбарын хувийн хэрэг бүрдүүлэн хөтөлж бүртгэлд оруулсан ба хугацаа болоогүй байгаа болно.

Сумын малчдын чуулганы үеэр аймгийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтэн, БОЭТ-ийн эхо, дотор, эмэгтэйчүүдийн эмч нар нэг өдрийн турш суманд ажиллаж, элэгний В,С вирус, хеликобактер, үе мөч, сахарын шинжилгээг хийж 300 гаруй малчин хамрагдаж, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж 300 гаруй мал бүхий иргэд хамрагдав.

Анги дэвших болон төгсөх ангийн сурагчдын шалгалтын дунд ангийн АВ- 40%, СХТ-100%, ахлах ангийн АВ-38%, СХТ-100%-ийн үзүүлэлттэй шалгагдав.

Багш нар багш, ангийн журнал, хичээлийн жилийн эцсийн тайлан мэдээ, анги удирдсан багш нар ангийн 4 дүгээр улирлын дүн мэдээ, жилийн эцсийн тайлан гаргаж, анги танхим, сурагчдын хувийн хэрэг, сурагч нэг бүрийн дүнгийн хуудас, шалгалтын оноог нэгтгэн боловсролын мэдээллийн системд шивж, бүрэн дунд боловсролын 12 дугаар ангийг өдрөөр 38 сурагч, дүйцсэн боловсролоор 2 нийт 40, суурь боловсролыг өдрөөр 33 сурагч, дүйцсэн боловсролоор 10 сурагч нийт 43 төгсөгчийн баталгаажуулалтыг хийж аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлэв.

Элсэлтийн ерөнхий шалгалтад 30 сурагч, Монгол хэл бичгийн шалгалт болон өөрийн сонгосон хичээлийн шалгалтад бүрэн хамрагдав. “Номын гэгээ”, “Авьяс”, “Багш хөтөлбөрүүдийн тайлан, мөн багш, ажилчдын шинэчилсэн судалгаа болон ажлын ачааллын судалгааг нэгтгэн БСУГ-т хүргүүлэв.

Дуут сум: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид 6 дугаар сард 1 удаа хуралдаж, 2 асуудал хэлэлцэн 2 тогтоол гарган хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Сумын ЗДТГазар 27 албан бичиг хүлээн авсаны 6 нь хугацаатай бичиг байв. 2 дугаар улиралд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Сумын Засаг даргын Тамгын газраас одонтой ээжүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, 108 ээжийн сүүн цацал өргөх, байгаль дэлхийгээ аргадах үйл ажиллагаа болж ээжүүдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулав.

2017 оны хагас жилийн байдлаар татварын орлогын төлөвлөгөө 10,200,0 төгрөг төлөвлөгдсөнөөс 13,200,0 төгрөг орж 125 хувийн биелэлттэй байна.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа МЭҮТНэгжүүдийн захиалгат вакциныг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас тээвэрлэн авч ирж вакцины хадгалалт, үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна. Хувиарлалтаар дотрын халдварт, шөвөг яр вакциныг хугацаанд нь бүрэн хийж дуусгав. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Нуман тамга” ТББ, газрын даамал, БАХ-үүдийн ахлагч нартай хамтран бэлчээрийн үр ашгийг дээшлүүлэх, эзэмших гэрээ байгуулах ажлыг хийж гүйцэтгэв.

Мал төллөлт, төл бойжилт, бод малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт мэдээлж, сумын хэмжээгээр нийт төллөх 66336 хээлтэгчээс 63748 төл хүлээн авав. Мал төллөлт 06 дугаар сарын 10-ны байдлаар 98.2 хувьтай байна.

ИНХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгаль орчны улсын байцаагч 6 дугаар сард бэлчээр зөрчсөн 45 малчин өрхөд мэдэгдэх хуудас өгч, зөрчлийг арилгаагүй зарим малчдад 1,680,000 төгрөгийн торгуулийг шийтгэврийн хуудсаар ногдуулсан байна.

Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн олон нийтийн оролцоог бодитой дэмжсэн багш, сурагч, ажилтны сурч, ажиллаж, хөгжих сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх зорилгоор байгууллагын ажилтнуудад ёс зүйн дүрэм хууль журмын талаар сургалт хэлэлцүүлэгийг амжилттай зохион байгуулав.

Сумын цагдаагийн хэсэгтэй хамтран эцэг эхчүүдэд хандсан хүүхдийг цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнд хүүхдээ өртөхөөс сэргийлэх, амралтын хугацаанд мотоцикл, автомашин унах эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, элсэлтийн ерөнхий шалгалтын үеэр хараа хяналтгүй явуулахгүй байх чиглэлд яриа сургалтыг сургуулийн удирдлагын зүгээс мэдээлэв.

УИХ-ын гишүүн О.Батнасан ирэх хичээлийн жилд сургуульд элсэх элсэгчдэд 50 ширхэг формын хувцас бэлэглэж, хангалт 97 хувьтай байна.

“Бага боловсролын чанарын шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд бага ангийн сурагчдын STEM сургалтын 3.219.000 төгрөгийн хэрэглэгдэхүүн УИХ-ын гишүүн О.Батнасангийн дэмжлэгтэй олгогдсон ба энэ чиглэлээр бага ангийн 2 багш, сургалтын менежерийг сургалтанд хамруулав.

1-12 дугаар ангийн 12 бүлгээс 37 хичээлээр шалгалт авахад давхардсан тоогоор шалгагдвал зохих 629 хүүхдээс 629 хүүхэд шалгалтанд орж, нийт хүүхдийн 0.49% буюу 31 хүүхэд дахин шалгалт өгч 100%-н амжилт, 39.9% чанартай шалгагдлаа.

Улсын шалгалтыг нууцлалын өндөр түвшинд бэлтгэж сургуулийн сургалтын менежерүүд БСУГ-ын дарга нартай нууцлалын гэрээ байгуулан ажиллав. 5, 9, 12 дугаар ангийн улсын шалгалтын дүн 100% амжилт, 41.5%-н чанартай шалгагдав.

Сургуулийн захирлын тушаалаар батлагдсан шалгалтын комисс нийт 2460 минут буюу 41 цагийн шалгалт авч 3320 минут буюу 55 цагийн хугацаанд засалтын ажил, 1235 минут буюу 25 цагийн хугацаанд мэдээллийн системд шивэлт хийж хүн нэг бүр 19.4 цагийн ажил хийж гүйцэтгэв.

Хамран сургалт 100%, үүнээс 5 дугаар анги 17, 9 дүгээр анги 17 дүйцсэн хөтөлбөрөөр 12 сурагч, 12 дугаар анги өдрөөр 19, дүйцсэн хөтөлбөрөөр 1 нийт 66 суралцагч бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшлээ.

2017-2018 оны хичээлийн жилийн элсэлтийн байдалд судалгаа хийж үзэхэд 1 ангид элсэх хамран сургах тойргийн хүрээнд 47 хүүхдээс 22 хүүхэд элсэн суралцаж байна.

Сумын Эрүүл мэндийн төвд **16 хүн хэвтэн эмчлүүлж**, алсын дуудлагад 25 удаа явж, 131 хүнийг эмчийн үзлэгт хамруулж, 5 эхийг жирэмсний хяналтанд авч, эхний 3 сартай 4, 4-6 сартай 2 эхийг "В" вирусын вакцины 1 дэх тунд хамруулж эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэв.

Манхан сүм: Уулын бүсийн залуучуудын чуулга уулзалтыг Ботгон багт зохион байгуулж, цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар болов.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Эх үрсийн баярыг Засаг даргын А/52 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж сумын хэмжээнд амжилттай зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Алдарт эх”-ийн I, II одонгоор нийт 21 шагнагдаж сумын удирдлагууд эхчүүдэд одонг гардуулан өгөв. “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, албан тушаалтанууд холбогдох мэдээллийг иргэдэд хүргэж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч сонирхсон асуултанд нь хариулт өгөв.

Анги дэвших болон төгсөх шалгалтанд давхардсан тоогоор 1073 хүүхэд хамрагдаж стандарт хангалт 100%, АВ-ийн эзлэх хувь 34,04% шалгагдав.

Сумын Эрүүл мэндийн салбар зөвлөл 50 залуу гэр бүлийн эцэг эхийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулж, тэдний нрх зүйн боловсролыг нэмэгдүүлэв.

4 багийн сургуулийн өмнөх насны хүүхдийг хамруулсан гэр цэцэрлэгийн сургалтыг зохион байгуулж, тус сургалтанд 120 хүүхдийг хамруулж мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авав. Байгууллагын гадна дотоод орчны засварын ажлыг хийж гүйцэтгэв.

Багшийн хөгжил, Авьяас, Номын гэгээ хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг хугацаанд нь гаргаж аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлэв.

Сумын эрүүл мэндийн төв нь 4 их эмч, 22 ажилтан, нийт 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 06 дугаар сарын 23-ны байдлаар 384 хүнд үзлэг шинжилгээ хийсэн бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт 171 хүн хамрагдаж эмнэлэгт 28 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна.

Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 40 хүүхэд хамрагдаж, 2 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 9 дуудлаганд түргэн шуурхай үйлчлэв.

0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчилж 90 хувийг тендэрээс авч хэрэглэсэн.

Мөнххайрхан сүм: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдааныг зарлан хуралдуулж, Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлого буюу “Ухаалаг малчин” хөтөлбөр, сумын төвийн мал бүхий өрхөд тавигдах шаардлага, түүнийг зохицуулах журамд өөрчлөлт оруулах тухай, хөх нуурын амралтын газарт амрагч, жуулчдаас авах хураамжийн хэмжээг тогтоох тухай, Сумын 90 жилийн ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, бүтээлч ажил, ойн бэлтгэл ажлын явцын тухай, сумын 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр тусгай хөтөлбөрийн дагуу хүүхдийн баяр зохион байгуулж, алдарт эхийн 2 дугаар зэргийн одонгоор 6 эх шагнагдаж, Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан 2017-2018 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэн суралцах хүүхдүүдийн хичээлийн хэрэглэл, форм өгсөнийг сум орон нутгийн удирдлагууд дамжуулж, гардуулав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах 4 хэсэгт ахлах зохион байгуулагчид, мэдээлэл технологийн даамал, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудыг томилон нийт 32 төрийн албан хаагч, 4 цагдаагийн ажилтан, 6 авто машин,

2 гэр, бусад тоног төхөөрөмжүүдийг дайчлан ажиллав. Сонгууль зохион байгуулах хугацаанд ноцтой алдаа дутагдал, зөрчил маргаан гараагүй болно.

Сумын 90 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүдийн хурлыг зохион байгуулж ойн хандив төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Ойн түүхэн номын эх бэлтгэж, цэцэрлэгт хүрээлэнгийн хайс татаж, мод тарих, наадмын талбайд тор татах, усалгаажуулж, гудамж төслийг хэрэгжүүлж, явган зам, хайс хамгаалалт хийв.

Орон нутгийн чанартай замыг ажилтан албан хаагчдын хүчээр засварлаж, нийтийг хамарсан ажлын хүрээнд 10 бүтээн байгуулалтын ажил хийгдээд байна. Мөн залуу малчдыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 4 малчныг сонгон нэг өрхийг 4.0 сая төгрөгөөр мал авч малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэв.

Альпинад-2017 улсын аварга шалгаруулах уулын аврилтыг Мөнххайрхан ууланд хийхээр төлөвлөж, уг аврилтанд 250 гаруй уулчид оролцохоор төлөвлөн бэлтгэл ажлыг хангаад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор баталсан “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/94, А/193 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын “Хуваарь батлах, чиглэл өгөх тухай” 2017 оны А/200 дугаар тушаалыг үндэслэн үйлчлэх хүрээний 40-65 насны даатгуулагчийг элэгний В, С вирусийн шинжилгээнд хамруулах ажил өрнөж, тайлант сард В, С вирусын шинжилгээнд 40-65 насны нийт хамрагдвал зохих 487 хүнээс 236 хүн ам хамрагдаж, хамралт 48 хувьтай байна. Эдгээр иргэдийн мэдээллийг тусгай программд нийт 100 хүний үзлэгийг шивж оруулав.

“Эх үрсийн эрүүл мэндийг дэмжих” өдөр буюу 2017 оны 06 сарын 01-ны өдөр эрүүл мэндийн төвийн сургалтын 2 дугаар баг, НЭМА, сумын хүүхэд хамгааллын багтай хамтран хүүхэд багачуудад зориулсан “Хөгжимт хөдөлгөөн” сэдэвт тэмцээн зохион байгуулж тэмцээнээс шалгарсан 3, 5 настай 2 хүүхдийг шагнаж урамшуулав. Эрүүл мэндийн төвөөс “Эрүүл чийрэг хүүхэд” төрлөөр шалгаруулахад 12 жилийн сургуулийн 5 дугаар ангийн сурагч Э.Тэргэл шалгарсан, мөн сургалтын 2 дугаар багийн гишүүн Борт багийн эмч О.Буяннэмэх багийнхаа сумын төвийн өрхүүдэд “Архи, тамхины хор уршиг” сэдэвт сургалт зохион байгуулж 22 хүнийг хамруулав. Вируст гепатит хөтөлбөрийн чиглүүлэгч А.Хандсүрэн сумын төвийн өрхүүдийг элэгний В, С вирусийн шинжилгээнд хамруулах ажлыг лаборант Б.Батсайхантай хамтран зохион байгуулж шинжилгээнд хамрагдсан иргэдэд элэгний В, С вирусын талаар мэдээллийг өгч ажиллав.

“Багш шавийн уулзалт” сургалт аймагт зохион байгуулагдаж, тус сургалтанд эрүүл мэндийн төвийн 11 ажилтан оролцож их эмч, сувилагч, тусгай дунд мэргэжилтэн, эм зүйч гэсэн төрлөөр мэргэжил тус бүрт зохион байгуулагдсан АШУҮИС-н багш нарын бэлтгэсэн сургалтанд амжилттай оролцож 2 багц цагийг бүрдүүлэв.

2017 оны 6 сарын 5-23-ны хооронд эмнэлгийн дотоод засварын ажлыг байгууллагын ажилчдын оролцоогоор хийж гүйцэтгэсэн ба сумын 90 жилийн ойгоор барих гэрийг будаж янзлан эмнэлгийн хашаандаа барьж бэлэн болгов.

Сумын 90 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд цэцэрлэг анги бүлгүүдийн дотор болон гадна орчинд анхаарч, чацарганы 50 суулгац, 300 ширхэг гоёлын хайлаас, цэцэг олон настын үр суулган тарьж, ногоон байгууламжийн хашаа хамгаалалтыг сайжруулж, тор татав

Гадна орчны өнгө үзэмжийг засаж, зочид төлөөлөгчдийг хүлээж авах бэлтгэл хийгдэж байна.

Сумын орон нутгийн төсөвт байгууллагууд болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хэвийн хэмжээнд явагдсан ба орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 22404.5 мян/төг орон нутгаас төсөвт төвлөрөх орлогоор 1479.9

мян/төг төвлөрч сумын ИТХ-д 3160.2 мян/төг, ЗДТГ-г 20724.2 мян/төгрөгийг тус тус санхүүжилтэнд олгов.

Орон нутгийн хөгжлийн санд санхүүжилтээр 11000.0 мян/төг ирснээс МЭУСАХ-ний санхүүжилтэнд 4100.0 мян/төг-ийг 2 мал эмнэлэгт хувиарлан олгож, үлдсэн 5000.0 мян/төг-ийг төлөвлөгдсөн бүтээн байгуулалтын ажилд /Гудамж төслийн санхүүжилтэнд/ зарцуулав.

Сумын 90 жилийн ой угтсан бүтээн байгуулалтын ажилд аймгийн Засаг даргын эрх шилжүүлэлтээр 10000.0 мян/төг ирснийг тус сумын төвд байгуулж буй “Цэцэрлэгт хүрээлэн”-гийн хашаа худалдан авах, тээвэрлэж ирэх, явган замын хавтан, цемент худалдан авах үйл ажиллагаануудад зарцуулав. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээр нийт 144656.7 мян/төг ирснийг 12 жилийн сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудад хуваарийн дагуу санхүүжилт олгож зарлагын гүйлгээнүүд хийгдэв.

2017 оны 6 дугаар сарын 20-нд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 4 дүгээр хуралдаан хуралпаж, 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай илтгэл тавьж үлдэгдлийн 684.2 мянган төгрөгийг суурь зардалдаа оруулан батлуулав. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт нь 5560.0 мянган төгрөгөөр хасагдаж ирсэн тул 2017 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс орон нутгийн зам засах зардлаас 2000.0 мянган төгрөг, наадмын талбайн тохижуулах зардлаас 1060.0 мянган төгрөг, тракторын сэлбэг авах зардлаас 500.0 мянган төгрөг, болзошгүй зардлаас 2000.0 мянган төгрөгийг тус тус хасаж тодотгох өөрчлөлт хийгдэв. Урьд оны зарцуулагдаагүй үлдэгдэл 684.2 мянган төгрөг, нэмж олохоор төлөвлөгдсөн 6000.0 мянган төгрөг бүгд 6684.2 мянган төгрөгөөр суурь орлогоо нэмэгдүүлэн ИТХ-ын суурь зардалд 1504.8 мянган төгрөгийг, ЗДТГ-ын суурь зардалд 5179.4 мянган төгрөгийг тус тус хувиарлан батлуулав.

Цэцэг сум: Сумын ИТХурал хуралдаж хагас жилийн ажлаа тайлагнаж, Алдар эхийн I, II дугаар одонгоор шагнагдах эхчүүдийн нэрсийг баталж тогтоол гаргав.

Хагас жилийн малын тооллого болж нийт 74 өрхийг түүврийн аргаар сонгож тооллогыг явууллаа. Сумын ЗДТГ-ын хамт олон сарын бүтээлч ажлын хүрээнд хуучин моторын байрыг засварлав.

Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газарт 44 албан бичиг, байгууллага иргэдээс 20 өргөдөл, гомдол ирсэнийг хүлээн авч, хууулийн хугацаанд хариуг нь шийдвэрлэж ажиллаа.

Тогтоол шийдвэрийн биелэлтүүдийг тооцож хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэв.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан 2 сарын аяны төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу зохион байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

Сайн дурын даатгалд 96 иргэн, Эрүүл мэндийн даатгалд 13 иргэн, жирэмсэн амаржих эхчүүдэд 6 хүнд тэтгэмж, 4 хүний тэтгэвэр тогтоолгов.

Сумын айл өрхүүдэд 12 өвөлжөө, хаваржааны гэрчилгээ шинээр олгож, 1 өвөлжөө, хаваржааны гэрчилгээ нөхөн олгосон.

Сумын төвийн бүх айл өрхүүдийн хашааны газрыг кадастрын зураглалыг гаргаж, өвөлжөө хаваржааны судалгаа, эзэмшил, өмчлөл ашиглагчын бүртгэлийг экситас ХХК-д гаргаж хүргүүлсэн ба сумын төвийн хашаа хороо эзэмшил газрыг хаягжуулж улс орон нутгийн чанартай авто замуудын зургийн төслийг гаргаж Геокад компанид хүргүүлэв. Аймгийн ХХААГазарт МЭҮТ-ийн болон МЭҮҮН, МЭ-н хагас жилийн тайлан мэдээг маягтын дагуу гаргаж хүргүүлэв.

Шинээр төрсөн 6 хүүхдийг бүртгэлд оруулж, овог нэр өөрчлөлт 2, нас баралт 2, гэрлэлт 2-ыг тус тус бүртгэлж мэдээллийн санд шивж баталгаажуулав. Иргэний

үнэмлэхийн хугацаа сунгуулсан 34 иргэнээс 25 насны сунгалт 12, 45 насны сунгалт 20 хүнд хийгдэв.

Тайлант сард 37 аж ахуй нэгжийн 334600 төгрөг, 8 аж ахуй нэгжийн 457600 төгрөг, 5 татвар төлөгчийн 150000 төгрөг, ААЭОрлого 60000 төгрөг, Байгалийн ургамал 30000 төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1287100 төгрөг төсөвт төвлөрүүлсэн. 10 татвар төлөгчид мэдэгдэх хуудас хүргэсэн. Урьд оны 26 татвар төлөгчийн 681350 төгрөгний өр, 68 татвар төлөгчийн 16051200 төгрөгийн өр байсныг бүрэн барагдуулж ажиллав.

Сумын цэцэрлэг “Номын гэгээ”, “Авьяс” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон өглөөлөг болон уламжлалт баяр болох дараах ажлуудыг зохион байгуулж, эцэг эхчүүд болон багш алаа хаагчидаа хамруулсан олон цогц арга хэмжээг санаачлан зохион байгуулж ажиллалаа.

Нутгийн онцлог уран нугаралтын дугуйланд 24 хүүхэд хамрагдаж, эцэг, эх, олон нийтийн оролцоонд түшиглэн, тэдэнтэй хамтран ажиллав.

Чадварлаг Ховдчууд дэд хөтөлбөрийн хүрээнд орчин үеийн шинэ соргог номыг татан авч уншигчдад дэлгэн, ард иргэд, албан байшууллагуудад цахим карт нээн ажиллуулж, номын сангийн баяжилтийг 10 шинэ номоор нэмэгдүүлж баяжилт хийгдэв.

Сумдын ард иргэдэд ардын язгуур урлагийг өвлөн үлдээх зорилгоор насны ангилалаар язгуур урлагийн дугуйлан хичээллүүлж, цаашид ардын язгуур урлагийн хамлагтай болох зорилготойгоор ажиллаж байна

Эрүүл мэндийн төвийн 80 жилийн ой болох бэлгэл ажлын хүрээнд бүтээн байгуулалт, тохижилтын үйлчилгээний ажил хийгдэж байна. Эх хүүхдийн эндэгдэл буурч, 5 хүртэлх насны 121 хүүхдэд амбулаториор эм үнэгүй олгов.

Үенч сум: Сумын Засаг даргын Тамгын газрын алба хаагчид хамт олноороо Цагаан түнгэ багийн “Хар Үзүүр”-ийн тариалангийн талбайд туршилтаар газрын самар 1,5 га-д тарив. Сумын Засаг даргын А/51 дүгээр захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж “Эх үрсийн баяр”ыг зохион байгууллаа. Тус баяраар эхчүүдийн дунд АХА танин мэдэхүйн тэмцээн, сурагчдын дунд шатар, гар бөмбөгийн тэмцээн, бөхийн барилдааныг зохион байгууллаа.

2016-2017 оны хичээлийн жилд 74 сурагч элсэлтийн ерөнхий шалгалт өгсөнөөс 66 сурагч өөрийн сонгосон хичээл тус бүрээр шалгалт өгөсөн. Багш нар хичээлийн жилийн эцсийн дүн мэдээ, тайлангаа нэгтгэн өгч 06 дугаар сарын 15-аас ээлжийн амралтаа авав. 2017 оны 6 дугаар сарын 17-24-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болсон “Мини” волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд биеийн тамирын багш С.Батжаргалын дасгалжуулсан баг амжилттай оролцож, 3 дугаар байр эзлэн хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлэв.

Сумын Эрүүл мэндийн төвийн 80 жилийн ой бэлгэл ажлын хүрээнд аймгийн төвд амьдарч байгаа нутгийн иргэдтэй нутгийн зөвлөл, сумын удирдлагууд уулзалт зохион байгуулж, цаашид хийхээр төлөвлөж буй ажлаа танилцуулж санал бодлоо солилцов. “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд сумын 40-65 насны эрүүл мэндийн даатгалаа төлсөн 73 иргэдийг вирусын шинжилгээнд хамруулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль амжилттай болж өндөрлөв. Согуульд 1179 дүгээр хэсэг буюу Цагаан түнгэ багт нэрсийн жагсаалтанд 401 сонгогч бүртгэгдсэнээс 232 сонгогч саналаа өгч саналын ирц 57.8% хувьтай, 1180 дугаар хэсэг буюу Нарийн гол багт нэрсийн жагсаалтанд 520 сонгогч бүртгэгдсэнээс 338 сонгогч саналаа өгч ирц 65%-хувьтай, 1181 дүгээр хэсэг буюу Жаргалан багт нэрсийн жагсаалтанд 373 сонгогч бүртгэгдсэнээс 196 сонгогч саналаа өгч ирц 52%-тай, 1182 дугаар хэсэг буюу Улиаст багт нэрсийн жагсаалтанд 255 сонгогч бүртгэгдсэнээс 183

сонгогч саналаа өгч ирц 71.7%-тай, 1183 дугаар хэсэг буюу Хилийн цэргийн 0130 дугаар анги нэрсийн жагсаалтанд 250 сонгогч бүртгэгдсэнээс 231 сонгогч саналаа өгч ирц 92.4%-тай, 1184 дүгээр хэсэг буюу Хөх Үзүүр багт нэрсийн жагсаалтанд 640 сонгогч бүртгэгдсэнээс 373 сонгогч саналаа өгч ирц 58.2%-тай нийт 2442 сонгогч нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэнээс 1553 сонгогч саналаа өгч 63.6%-ийн ирцтэй нэр дэвшигч М.Энхболд- 846 сонгогч буюу 54.4%, Х.Баттулга-477 сонгогч буюу 30.7%, С.Ганбаатар-218 сонгогч буюу 14% санал тус тус авав.

Эрдэнэбүрэн сум: Сумын ИТХ-ын ээлжит бус хуралдаан 2017 оны 06 сарын 27-нд болж 2017 оны төсвийн тодотголын тухай, нутаг бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах журамд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлав.

“Хүүхдийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг томилж, хөтөлбөр гарган уралдаан тэмцээнүүдийг Тунгалаг уст-шураг хоршоо, Аваргын ач хоршоо, Нутгийн өгөөж хоршоо, Бялзуухай цэцэрлэгийн эзэн Б.Лхагвасүрэн нар 67500 төгрөгөөр баярын үйл ажиллагааны арга хэмжээг ивээн тэтгэж, тус арга хэмжээнд оролцсон сургуулийн насны 150 хүүхэд, цэцэрлэгийн насны 50 хүүхдэд Хар ус багийн Засаг дарга Б.Батзаяа хувиасаа гарын бэлэг гардуулж, тэдэнд амжилт хүслээ.

АТБӨЯТХ-ийн улсын үзлэг 2017 оны 06 дугаар сарын 16-17-ны өдөр явагдаж 210 автомашин, 39 мотоцикл хамрагдаж татвар, төлбөрөө бүрэн төлж барагдуулав.

Татварт 9893800 төгрөг, агаарын бохирдлын төлбөрт 1143358 төгрөг төвлөрүүлээ.

Сумын ЭМНД-ын байцаагч П.Отгонтуяа 2017 оны 06 дугаар сард давхардсан тоогоор 210 малчин өрхийн 235 иргэдтэй уулзаж ЭМД-ын тухай хууль сурталчлан ЭМД-ын санд 7 малчны 725760 төгрөг төвлөрүүлсэн байна.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 415 өрх хамруулан судалгааг үр дүнтэй зохион байгуулав.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 6, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр дэмжих хөтөлбөрт 1, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4 малчин хамруулж, 4 малчинд 110 хонь, 452 ямаа бүгд 562 толгой мал гэрээгээр өгсөн.

Нийтийг хамарсан “Ногоон байгууламж” төсөл хэрэгжүүлэн ажилгүй 3 иргэнтэй гэрээ байгуулан ажиллуулж байна.

ОНХС-ийн санхүүжилтээр “Жишиг гудамж” хөтөлбөр хэрэгжүүлэн сумын төвийн 10 өрх банзан хашаа барьж тохижуулж байгаа нь сумын төвийн өнгө үзэмж, тохижилтонд сайн нөлөө үзүүлж байна.

”Хууль журам-миний амьдралд” аяны дарцаг дэвтрийг байгууллагуудаар аялуулж хууль сурталчилах, тэдний хуурь эрх зүйн боловсролын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.

Хагас жилийн мал тооллогыг түүврийн аргаар зохион байгуулж 97 малчин өрх хамрагдсан ба тооллогоор сум 280000 толгой мал тоологдов.

Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж сонгогчдын 71,29 хувь нь саналаа өглөө.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР